

Аймгийн дотоодын нийт бүтээгдэхүүний 2012 оны танилцуулга

Ойлголт

ДНБ-ий тооцоог ҮСХорооны дарга, Сангийн сайдын 2007 оны 7-р сарын 9-ний өдрийн 101/203 тоот хамтарсан тушаалаар баталсан “Дотоодын нийт бүтээгдэхүүн болон Үндэсний нийт орлого тооцох аргачлал”-ын дагуу тооцдог. Дотоодын нийт бүтээгдэхүүн нь эдийн засгийн үйл ажиллагааны цар хэмжээг харуулдаг макро эдийн засгийн чухал үзүүлэлт юм. ДНБ-ийг үйлдвэрлэлийн, эцсийн ашиглалтын, орлогын гэсэн 3 аргаар тооцдог. Нийт үйлдвэрлэлтээс завсрын хэрэглээг хасч нэмэгдэл өртгөөр тооцохыг үйлдвэрлэлийн арга гэнэ. ДНБ-ний үйлдвэрлэлийн аргын тооцоо нь эдийн засгийн үйл ажиллагааны салбараар хийгддэг ба эдгээр эдийн засгийн салбарын үйл ажиллагаа нь ДНБ-нд ямар хувь нэмэр оруулж байгааг харуулдаг.

Дотоодын нийт бүтээгдэхүүнийг тооцоходоо албан болон албан бус секторыг хамруулан тооцдог. Бизнес регистрийн санд (БРС) бүртгэлтэй, тухайн жилд үйл ажиллагаа явуулсан аж ахуйн нэгж, байгууллага (ААНБ)-ууд хамрагдаж, албан бус секторын хувьд түүвэр судалгааны мэдээлэл болон мэдээллийн бусад эх үүсвэрүүдийг ашиглаж тооцоог хийв.

ДНБ-ий хамрах хүрээ

Хөдөө аж ахуйн салбарын нэмэгдэл өртгийн тооцоог мал, тэжээвэр амьтдын тооллогын дүн, газар тариалангийн мэдээ болон бусад судалгааны үр дүнд үндэслэж хийсэн бөгөөд төрийн удирдлага, батлан хамгаалах, нийгмийн даатгалын үйл ажиллагааны салбар, боловсрол, эрүүл мэндийн салбарын хувьд улсын болон орон нутгийн төсвийн гүйцэтгэлээр, харин бусад салбарын хувьд 2012 оны үйл ажиллагааны мэдээ, тайлангийн гүйцэтгэлийг үндэслэн тооцоонд хамруулсан.

Аж үйлдвэр, бөөний болон жижиглэн худалдаа, зоогийн газар, барьцаалан зээлдэх үйл ажиллагаа, төрийн бус байгууллагын салбарт түүвэр судалгааны аргаар, бусад салбарын хувьд нэлэнхүй ажиглалтаар мэдээллийг цуглуулсан.

Нийт үйлдвэрлэлт

Нийт үйлдвэрлэлтийг зах зээлийн болон зах зээлийн бус үйлдвэрлэлт гэж ангилж тооцсон. Зах зээлийн үйлдвэрлэлд үйлдвэр, үйлчилгээ эрхэлдэг аж ахуйн нэгжүүдийн бүтээгдэхүүн, үйлчилгээний нийт хэмжээг тухайн оны үнээр үнэлж тооцсон. Зах зээлийн бус үйлдвэрлэлд ашгийн бус төр, захиргаа, нийгмийн даатгал, халамж, боловсрол, эрүүл мэнд, батлан хамгаалах, хэв журам, олон нийтийн байгууллага зэрэг нийгмийн нийтлэг үйлчилгээний хүрээний үйл ажиллагааг хамруулж нийт үйлдвэрлэлтийг урсгал зардлаар нь тооцсон.

Завсрын хэрэглээ

Завсрын хэрэглээнд үндсэн болон нэмэгдэл цалин хөлс, шимтгэл, үндсэн хөрөнгийн элэгдлээс бусад материалын зардал, тээвэр, албан томилолт, холбоо гэх мэт бүх зардлыг хамруулаг.

Нэмэгдэл өртөг

Нэмэгдэл өртөг гэдэг нь салбарын түвшинд тооцсон **дотоодын нийт бүтээгдэхүүн** гэж ойлгож болох бөгөөд үйлдвэрлэлийн аргаар тодорхойлохдоо нийт үйлдвэрлэлтээс завсрын хэрэглээг хасч тооцдог.

Өвөрхангай аймгийн ДНБ-ний 2012 оны гүйцэтгэл


2012 оны дотоодын нийт бүтээгдэхүүн оны үнээр **177.7 тэрбум** төгрөг болж, 2011 онтой харьцуулахад **42.4** хувь буюу **52.9 тэрбум** төгрөгөөр өслөө. Нийт үйлдвэрлэлтэд албан бус секторын /далд эдийн засаг/ үйлдвэрлэлт 7.2 хувийг эзэлж байна.

ДНБ-ний гүйцэтгэл аймгаар

(сая.төг)

	ДНБ		2012/ 2011	Дүнд эзлэх хувь	
	2011	2012		2011	2012
1.Хөдөө аж ахуй	68422.8	92750.7	135.6	54.9	52.20
2.Үйлдвэр,барилга	5163.9	8351.2	161.7	4.1	4.70
3.Үйлчилгээ	51147.5	76581.5	149.7	41.0	43.10
Дүн	124734.2	177683.4	142.4	100.0	100.0

Дотоодын нийт бүтээгдэхүүн, салбараар



ДНБ-ний бүтцийг хөдөө аж ахуй, аж үйлдвэр барилга, үйлчилгээ гэсэн ерөнхий салбаруудаар авч үзвэл: 52.2 хувийг ХАА-н салбар, 4.7 хувийг үйлдвэр, барилгын салбар, 43.1 хувийг үйлчилгээний салбарын бүтээгдэхүүний үйлдвэрлэл эзэлж байна.

1.Хөдөө аж ахуйн салбар

(сая.төг)

	ДНБ		2012/ 2011	ДНБ-нд эзлэх хувь	
	2011	2012		2011	2012
Хөдөө аж ахуй	68,422.8	92,719.4	135.5	54.9	52.2
Мал аж ахуй	62,755.9	86,449.20	137.8	50.3	48.7
Газар тариалан	5,664.4	6267.1	110.6	4.5	3.5
Ойн аж ахуй	2.5	3.10	124.0	0.002	0.002

Мал аж ахуйн салбарын нийт үйлдвэрлэлт 2012 онд оны үнээр 92.7 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оныхоос 35.5 хувь буюу 24.3 тэрбум төгрөгөөр өссөн.

Малын тоо, жилийн эцсийн байдлаар

(мян.тол)

Үзүүлэлт	жилийн эцсийн малын тоо, мян.тол			малын цэвэр өсөлт, мян.тол			малын бүтэц, хувиар		
	2010	2011	2012	2010	2011	2012	2009	2010	2011
Малын тоо	2010.6	2425.6	2970.7	-1609.6	415.0	545.1	100.0	100.0	100.0
том мал	1712.5	1605.2	2038.7	-762.0	-107.3	433.5	85.2	66.2	68.6
төл мал	298.1	820.4	932.0	-847.6	522.3	111.6	14.8	33.8	31.4

Мал тооллогын 2012 оны жилийн эцсийн дүнгээр нийт мал сүргийн тоо 2.9 сая толгой болж, 2011 оныхоос 545.1 мянган толгойгоор буюу нийт

мал 22.5 хувиар өссөн. Бүтцийнх нь хувьд авч үзвэл том мал 27.0 хувиар, төл мал 13.6 хувиар тус тус өссөн байна.

Мал аж ахуйн бүтээгдэхүүн үйлдвэрлэлтийн өсөлтийг бүтээгдэхүүн тус бүрээр нь харвал махны үйлдвэрлэл 1 дахин, сүүний үйлдвэрлэл 8.9 хувиар, ноосны үйлдвэрлэл 5.2 хувиар, арьс ширний үйлдвэрлэл 16.7 хувиар тус тус өссөн байна.

Махны үйлдвэрлэлийн өсөлтөд нөлөөлсөн хүчин зүйл нь бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн биет хэмжээний хувьд урд оноос 10.5 хувиар өссөн, бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн үнийн дүнгийн хувьд үхрийн мах 47.9 хувиар, хонины мах 42.2 хувиар, ямааны мах 48.1 хувиар, адууны мах 37.5 хувиар, тэмээний мах 18.1 хувиар тус тус өссөн байна. Өөрөөр хэлвэл 2012 онд махны дундаж үнэ хамгийн багадаа 18.1 хувь, хамгийн ихдээ 48.1 хувиар өссөн нь бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн үнийн дүнд шууд нөлөөлсөн байна.

2.Үйлдвэр, Барилгын салбар

(сая.төг)

Салбар	2011	2012	<u>2012</u> 2011 %	ДНБ-нд эзлэх хувь	
				2011	2012
Аж үйлдвэр	4187.20	7084.6	169.2	3.4	4.0
Барилга	976.70	1268.3	129.9	0.8	0.7
Дүн	5163.90	8352.9	161.8	4.1	4.7

Үйлдвэрлэлийн салбарын нийт бүтээгдэхүүн 2012 оны гүйцэтгэлээр оны үнээр 7.1 тэрбум төгрөгт хүрч, 2011 оныхоос 69.2 хувиар өсч, аймгийн нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэлтэд 4.0 хувийг эзэлж байна. 2012 оны бүтээгдэхүүний тооцоонд хамрагдсан аж ахуйн нэгж, цэг салбарын хувьд өмнөх оныхоос 120 гаруй нэгжээр нэмэгдэж 2011 оны бүтээгдэхүүн үйлдвэрлэлтээс өсөхөд шууд нөлөөллөө. Үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлтийн 26.6 хувийг хүнс, 22.0 хувийг дулаан, 27.8 хувийг алт олдборлолт, 23.6 хувийг бусад жижиг үйлдвэрлэлүүдийн бүтээгдэхүүн эзэлж байна.

Аж үйлдвэрийн салбарын бүтээгдэхүүн үйлдвэрлэлт, дэд салбараар


(сая.төг)

салбарууд	Нийт бүтээгдхүүн		Дүнд эзлэх хувь	
	2011	2012	2011	2012
Хүнсний бүтээгдхүүн үйлдвэрлэл	1460.5	1889.1	34.9	26.7
Дулаан, цахилгаан	724.9	1555.5	17.3	22.0
Хэвлэн нийтлэх	18.3	31.1	0.4	0.4
Нүүрс, алт олборлолт	952.9	1971.3	22.8	27.8
Ус ариутгал, усан хангамж	212.8	227.8	5.1	3.2
Бусад	817.8	1409.9	19.5	19.9
Дүн	4187.2	7084.7	100.0	100.0

Бүтцийнх нь хувьд үзвэл: аж үйлдвэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлтэд хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэлт 26.7 хувь, дулаан цахилгаан 22.0 хувь, хэвлэн нийтлэх 0.4 хувь, нүүрс, алт олборлолт 27.8 хувь, ус ариутгал, усан сан хангамж 3.2 хувь, бусад салбарын /блок, тоосго, гэрийн мод, оёдол, гутал гэх мэт / үйлдвэрлэлт 19.9 хувь тус тус эзэлж байна.

Барилгын салбарын бүтээгдэхүүн үйлдвэрлэлт нь 1268.3 сая.төгрөгт хүрч , өнгөрсөн оныхоос 29.9 хувиар өсч, ДНБ-нд 0.7 хувийг эзэлж байна.

Аж үйлдвэрийн салбарын ДНБ, салбараар, 2012 онд



3.Үйлчилгээний салбар

(сая.төг)

Салбарууд	2011	2012	2012% 2011	ДНБ-нд эзлэх хувь	
				2011	2012
Худалдаа	18,498.5	30,043.4	162.4	14.8	16.9
Зоогийн газар	311.6	409.5	131.4	0.2	0.2
Зочид буудал	228.5	365.5	159.9	0.2	0.2
Тээвэр холбоо	1,373.3	1,461.6	106.4	1.1	0.8
Санхүү даатгал	3,391.9	7,512.4	221.5	2.7	4.2
Үл хөдлөх хөрөнгө түрээс бие хүнд үзүүлэх үйлчилгээ	859.2	1,106.2	128.8	0.7	0.6
Төсөвт байгууллага	25,868.1	34,815.9	134.6	20.7	19.6
Ххэвшлийн эрүүл.мэнд	154.4	167.2	108.3	0.1	0.1
Төрийн бус байгууллага	368.2	372.4	101.1	0.3	0.2
Мал эмнэлэг	93.8	211.0	224.9	0.1	0.1
		116.4			0.1
НБ-ий дүн	51,147.5	76,581.5	149.7	41.0	43.1

Аймгийн нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэлтийн 43.1 хувийг үйлчилгээний салбарын бүтээгдэхүүн үйлдвэрлэлт эзэлж өнгөрсөн онтой харьцуулахад 49.7 хувиар өссөн. ДНБ-нд төрийн байгууллагуудын бүтээгдэхүүн үйлдвэрлэлт 19.6 хувийг эзэлж байна.

Худалдаа

Худалдааны салбарын үйлдвэрлэлт нь 2012 онд 2011 оныхоос 62.4 хувиар нэмэгдэж, аймгийн дотоодын нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэлтэд 16.9 хувийг эзэлж байна. 2012 онд хүн амын өргөн хэрэглээний бараа үйлчилгээний үнэ нэмэгдэж инфляци өссөн.Үнийн өсөлттэй худалдааны салбарын үйлдвэрлэлтийн өсөлт шууд хамааралтай. Худалдааны салбарт

бий болсон үйлдвэрлэлтийн 60.0 хувийг албан бус секторт үйл ажиллагаа эрхлэгчид бий болгосон байна.

Тээвэр холбоо

Тээвэр, холбооны салбарын үйлдвэрлэлт 2012 онд 2011 оныхоос 6.4 хувиар өсч, аймгийн ДНБ-үйлдвэрлэлтийн 0.8 хувийг эзэлж байна.

Аймгийн нэг хүнд ногдох дотоодын нийт бүтээгдэхүүн

(мян.төг)

	2011	2012	$\frac{2012}{2011}$ %
Нэг хүнд ноогдох нийт бүтээгдэхүүн	1111.0	1595.2	143.5

Аймгийн нэг хүнд 2012 оны байдлаар 1595.2 мян.төгрөг ноогдож өнгөрсөн оныхоос 43.5 хувиар буюу 484.2 мян. төгрөгөөр өссөн байна.

Статистикийн хэлтэс